



## 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ГАЗАРЗҮЙН УЛСЫН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

### Үндэслэл

Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 12 сарын 04-ний өдрийн А/420 дугаар тушаал, Газарзүйн олимпиадын дэд хорооны 2024 оны 9 сарын 16-ны 02 тоот тогтоолд үндэслэн энэхүү удирдамжийг боловсруулав. Ерөнхий боловсролын сургуулийн багш, дунд, ахлах ангийн суралцагчдын дунд газарзүйн олимпиад зохицуулахтай холбоотой харилцааг тус журмаар зохицуулна.

### Нэг. Зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн газарзүйн хичээлийн сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах, сурагчдын бүтээлч сэтгэлгээ, чадварыг хөгжүүлж, Газарзүйн ухааныг сонирхон судлах сурагчдын тоог нэмэгдүүлэх, багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ. Тус олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн нийт газарзүйн багш, суралцагчид хамрагдана.

### Хоёр. Ерөнхий зохион байгуулалт.

Улсын газарзүйн олимпиад нь 3 даваатай байх ба даваа бүрийн зохион байгуулагдах хугацаа ба ангилал дараах байдлаар зохицуулагдана.

#### Нэгийн даваа

- 2024 оны 10 сарын 31-ний өдөр Монгол улсын бүх ЕБС дээр зохион байгуулна.
- Нэгийн давааны асуулт даалгаврыг сургуулийн газарзүйн багш нар хэлэлцэн боловсруулна.

#### Хоёрын даваа

- Олимпиадын хоёрын даваа 2024 оны 12 сарын 11-ний Лхагва гарагийн 10:00 цагт аймгийн төвүүд ба Улаанбаатар хотод нэгэн зэрэг явагдана.
- Оролцогчдын хоёрын давааны бүртгэл, зохион байгуулалт, засалтыг Аймаг, Нийслэлийн БШУГ мэргэжил, аргазүйн удирдлагаар ханган ажиллана.
- Олимпиадын хоёрын давааны асуулт даалгаврыг Газарзүйн Улсын олимпиад зохион байгуулах дэд хороо боловсруулж, цахим шуудангаар илгээнэ. Илгээсэн материалын нууцлал ба хэвлэх, хувилах, цагийн менежментийг БШУГ хариуцна.
- Олимпиадын хоёрын давааны үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой санал гомдлыг БШУГ хүлээн авч, шийдвэрлэнэ.
- VIII болон XI дүгээр ангийн сурагчид IX болон XII ангийн олимпиадад дэвшин оролцохыг зөвшөөрнө.
- Дараагийн даваанд шалгарсан багш, сурагчийн мэдээллийг аймаг, нийслэлийн БШУГ-аас батламж олгох ба хүснэгтийн дагуу мэдээллийг

газарзүйн олимпиадын дэд хорооны [tsendsuren.ts@num.edu.mn](mailto:tsendsuren.ts@num.edu.mn) хаягт 2024 оны 12 сарын 20-ны дотор илгээнэ.

№	Овог нэр	Хүйс	РД	Сургууль, анги	Утасны дугаар	И-мэйл хаяг

#### Гурвын даваа

- Хоёрын даваанд гүйцэтгэлийн 70% биелүүлсэн багш сурагчид гурвын даваанд оролцох эрх авна.
- Газарзүй хичээлийн Улсын олимпиадын гурвын даваа 2025 оны 4 дугаар сарын 07, 08, 09-ний даваа, мягмар, лхагва гарагт Улаанбаатар хотод зохион байгуулагдах бөгөөд хоёрын даваанаас шалгарсан багш, сурагчид оролцоно.
- Гурвын давааны бүртгэлийг 2025 оны 04 дугаар сарын 07-ны өдөр 10-17 цагийн хооронд хийнэ.
- Бүртгүүлэхдээ БШУГ-ын батламж, иргэний үнэмлэх (төрсний гэрчилгээ), цээж зураг 2 хувь, томилолтын хуудсын хамт авч ирнэ.

#### Гурав. Үйл ажиллагаа

- Олимпиадын гурвын даваанд сурагчид эхний өдөр онолын даалгавар, хоёр дахь өдөр дадлага ажил гүйцэтгэнэ. Онолын даалгавар болон дадлага ажлын нэгдсэн дүнгээр сурагчдын олимпиадын эцсийн дүн тодорхойлогдоно.
- Олимпиадын гурвын давааны багш нарын олимпиад эхний өдөр явагдаж дүнгээ гаргана. Олимпиадын 2 дахь өдөр багш нарт зориулсан онол, аргазүйн сургалт зохион байгуулагдана.
- Олимпиадын гурвын давааны үйл ажиллагаа, засалт, зохион байгуулалттай холбоотой санал гомдлыг даруй олимпиадын хорооны дарга, нарийн бичиг нарт бичгээр ирүүлэх ба дэд хороо хуралдан санал гомдлыг шийдвэрлэнэ.

#### Дөрөв. Шагнал, урамшуулал

- 12-р ангийн ангилалд хоёрын даваанд шалгарсан сурагчид ЭЕШ-ын босго оноог хангасан нөхцөлд МУИС-ийн Газарзүйн мэргэжлийн хөтөлбөрт суралцах эрхийн бичиг олгоно.
- Газарзүйн хичээлийн Улсын олимпиадын гурвын даваанд багш нараас тэргүүн байр 1, дэд байр 2, гутгаар байр 3-ыг, Сурагчдаас 9-р анги, 12-р анги тус бүр тэргүүн байр 1, дэд байр 3, гутгаар байр 6-г шалгаруулж медаль, өргөмжлөл олгоно.

